Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# “ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН
# 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь | ХШҮ хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго** | | | | | | | | | |
| 1.1**“Замын-Үүд” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх зорилтын хүрээнд:** | | | | | | | | | |
| Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.17. | | | | | | | | | |
| 1.1.1 | “Замын-Үүд” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, дэмжлэг үзүүлэх, холбогдох мэдээллээр хангах, Засгийн газраар батлуулахад | АХБ-ны техник туслалцааны төслийн 285.0 сая төг. | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийгдэж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, Засгийн газраар батлуулсан байна. | Монгол Улсын Шадар сайд, Барилга хот байгуулалтын сайд нарын хамтарсан чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын даалгавар. | “Замын-Үүд” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийгдсэнээр чөлөөт бүсэд бизнес худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, тээвэр логистик бүхий Эдийн засгийн хамтын ажиллагааны | Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан нарын баталсан 2020 оны 2020/05 тоот дугаартай “Замын-Үүд” чөлөөт бүсийн 900 га газрын Хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө \тодотгол\, 300 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврын дагуу Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Зураг төслийн “ТГТ” ХХК 2020.06.18-ны өдрийн №159273-S53714 гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн. “ТГТ” ХХК нь ерөнхий төлөвлөгөөний иж бүрдлийг | 85 | 90 | Боловсруулсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөг сайжруулан Засгийн газрын хуралдаанаар батлуулахаар хүлээгдэж байна. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжлэг үзүүлэх; | | | | бүс байгуулах төлөвлөлт хийгдэх суурь нөхцөл бүрдсэн байна. | 2023.03.03-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн бөгөөд материалтай Захирагчийн ажлынсанал дүгнэлт боловсруулж 2023.04.09-ний өдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүүд танилцуулсан. "ТГТ" ХХК-ийн боловсруулсан ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө нь БНХАУ-ын Зөжианы Их сургуулийн боловсруулсан хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөө болон хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийн үндсэн зарчимтай нийцээгүй тул дахин боловсруулах санал гаргаж саналыг 2023.07.04-ний өдөр зохион байгуулсан Хамтын ажиллагааны бүсийн хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүнд танилцуулан "Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөг БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулахыг дэмжсэн. Хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг Захирагчийн ажлын албанаас боловсруулан 2023.12.15-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн сайд, Барилга, | | | х бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн боловч зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтэд хүрээгүй. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хот байгуулалтын сайд нараар батлуулсан. | | | |
| **1.2.Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллах зорилт** | | | | | | | | | |
| • Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл 2.1.139.<br>• Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.17.<br>Талын зам үндэсний хөтөлбөр 3.4.2. | | | | | | | | | |
| 1.2.1 | Чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн төлөвлөгөө, ногоон байгууламжийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | АХБ-ын 713.968 ам.долларын багц ажлын санхүүжилтэд багтсан | Ногоон байгууламж, мод үржүүлгийн хүлэмжийн төсөл боловсруулагдсан байна. | Чөлөөт бүсэд 20 га газарт ногоон байгууламж байгуулах төлөвлөлтийн ерөнхий төлөвлөлтийн зургийг боловсруулж байна. | Тэрбум мод үндэсний хөтөлбөртэй уялдаж, гадаадын хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөртэй хамтран ногоон байгууламж байгуулах төлөвлөлтийн төсөл, зураг төсөв боловсруулсан байна. | "Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 20 га газарт цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах ажлыг 2022 онд эхлүүлж, Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургууль цэцэрлэгт хүрээлэнгийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан. АХБ-ны "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн CS-01 багц ажлын хүрээнд /Ландшафт цаг уурын өөрчлөлтийн дасан зохицол/ нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд зураг төслийг Сонголт дизайн ХХК-д гүйцэтгэж байна.<br>Тус ажлын даалгаврын төслийг Захирагчийн ажлын албанаас боловсруулан 2023.06.27-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дашпүрэв батлуулав. Ажлын гүйцэтгэл | 80 | 70 | Тайлан оновчтой ойлгомжтой тайлагнах. Арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээн тодорхой ажлууд хийгдсэн гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байна. Зорилтот түвшинд ногоон байгууламж байгуулах төлөвлөлтийн төсөл, зураг төсөв боловсруулсан байна гэсэн бөгөөд тус ажил бүрэн хэрэгжээгүй байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ТХН-ээс ирүүлсэн 2023.12.07-ны өдрийн мэдээгээр 90% байна. | | | |
| 1.2.2 | “Замын-Үүд” чөлөөт бүсэд гадаад дотоодын хөрөнгө оруулалт татах, чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээг зохион байгуулах; | Урсгал зардлаас | Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад зориулан БНХАУ-д 1 удаа, Монгол Улсад 1 удаа арга хэмжээ зохион байгуулсан байна. | “Замын-Үүд” чөлөөт бүсэд 2022 оны байдлаар 18,2 тэрбум төгрөгийн бодит хөрөнгө оруулалт хийгдсэн. | Хөрөнгө оруулалтыг арга хэмжээ зохион байгуулагдаж, чөлөөт бүс дэх гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ 10-20 хувиар нэмэгдсэн байна. | Чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт татах чиглэлээр гадаадад БНХАУ-ын Хөххот, Эрээн хотуудад үзэсгэлэн, экспод оролцож ажилласан бол дотоодод чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж хамтран ажиллах чиглэлээр танилцуулга хийж ажиллалаа.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 6 минутын видео танилцуулга хийгдэж бэлэн болсон бөгөөд байгууллагын цахим хуудас болон арга хэмжээнүүд дээр цацагдан олон нийтэд хүргэсэн. Мөн байгууллагын танилцуулга тараах материалын эхийг бэлтгэн Англи 50, Монгол хэлээр 50 хувь нийт 100 ширхгийг хэвлэн бэлтгэж, олон нийтэд хүргэсэн.<br>Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор “Замын-Үүд” сумын Хаан банкны Захирал Н.Төрмөнхтэй 2023.03.20-ний өдөр уулзалт зохион байгуулж, уулзалтаар чөлөөт бүсийн үйл ажиллагаа, дэд бүтэц, бүтээн байгуулалт, хууль эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн мэдээллийг өгч ажиллалаа.<br>“Тээвэр хөгжлийн банк” болон “ККТТ-/Qpay/” ХХК-уудтай | 80 | 90 | Арга хэмжээний хүрээнд зорилтот түвшинд хэрхэн хүрсэн талаар тайлагнах. Зохион байгуулсан бүх үйл ажиллагааг тайланд тусгасан байна. Зорилтын хүрээнд хийсэн ажлаа тодорхой ойлгомжтой тайлагнаж үр дүнг тусгах. Тайлан хангалтгүй. Гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ 10-20 хувиар нэмэгдсэн байна гэсэн зорилтын хэдэн хувьд хүрсэн бэ? |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023.03.12-нд уулзалт зохион байгуулж "Замын-Үүд" чөлөөт бүсийн үйл ажиллагааг танилцуулан, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд "Qpay" үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх талаар мэдээлэл өгөв.<br>"Замын-Үүд" чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдыг нэгтгэх, мэдээ мэдээллээр хангах зорилгоор facebook групп үүсгэж хамтран ажиллаж байна.<br>2023.09.07-ны өдөр "БНХАУ-ын Олон улсын эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын Эрээн хот чуулга уулзалт ба үзэсгэлэн худалдаа", "Монгол-Хятадын Экспо"-д тус тус оролцож, арга хэмжээний үеэр чөлөөт бүсийн үйл ажиллагааг сурталчлан танилцуулга хийж, холбогдох албаны төлөөллүүдтэй уулзалт хийсэн.<br>ОХУ-ын Буриад улсын Эдийн засгийн сайдыг 2023.08.30-нд "Замын-Үүд" чөлөөт бүсэд хүлээн авч, чөлөөт бүсийн хөгжлийн бодлого хууль эрх зүйн орчин, дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар мэдээлэл өгөв.<br>Чөлөөт бүсийн тухай танилцуулга PPT болон БНХАУ-ын төлөвлөлтийг JICA-ын дэд бүтэц, хот байгуулалтын асуудал хариуцсан хөтөлбөрийн ажилтан Б.Заяад 2023.01.05-нд хүргүүлэн ажилласан.<br>2023 оны 06 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Монгол-Хятад- | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Оросын Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимуудын Худалдаа, Эдийн Засгийн 16 дахь удаагийн нэгдсэн чуулганд Замын-Үүд чөлөөт бүсэд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн талаар танилцуулав.<br>2023 оны 05 дугаар сарын 15-нд Монголын логистикийн холбооны ерөнхийлөгч А.Мөнхболдтой уулзалт зохион байгуулж Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд хуурай боомт байгуулах боломжийн талаар мэдээлэл танилцуулгатай танилцаж, чөлөөт бүсийн тээвэр логистикийн бүсэд хөрөнгө оруулалт татах талаар мэдээлэл солилцож цаашид логистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалт татах чиглэлээр хамтарч ажиллахаар тохиролцов.<br>БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Худалдааны групп” ХХК-тай 2023.10.03-нд уулзалт зохион байгуулж, хөрөнгө оруулалт татах чиглэлээр танилцуулга хийн ажиллав.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт хийхээр судалж буй “Нэг бүс-Нэг зам санаачилага” сангийн холбогдох ажилтантай 2023.11.20-нд уулзалт хийсэн.<br>Байгууллагын цахим хуудас болох zfz.gov.mn, “Замын-Үүд чөлөөт бүс”-Zamiin-Uud free zone гэсэн фэйсбүүк хуудаст | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дараах мэдээллүүдийг бэлтгэн байршуулж түгээлт хийв.<br>Үүнд:<br>“Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хоёр талын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх уулзалт боллоо /2023.04.23 БНХАУ-Эрээн хот/;<br>“Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийг эрчимжүүлэх чиглэлээр орон нутгийн холбогдох байгууллагуудтай уулзалт хийлээ /2023.04.25 Замын-Үүд сум/;<br>БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Дэд ерөнхий Консулыг хүлээн авч уулзлаа /2023.05.18 Улаанбаатар хот/;<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөллүүдтэй хамтын ажиллагааны чиглэлээр уулзалт хийлээ /2023.06.07 Улаанбаатар хот/;<br>“Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн CS-03 багц ажлыг эрчимжүүлэх чиглэлээр зөвлөлдөх уулзалт боллоо /2023.11.03 Улаанбаатар хот/;<br>“Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн менежментийн зөвлөх үйлчилгээний/ CS-02/ гарааны уулзалт боллоо /2023.11.09 Улаанбаатар хот/;<br>Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн үйл ажиллагаанд “Дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг”-ийн хурал боллоо /2023.06.12 Улаанбаатар хот/; | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүний хурал боллоо /2023.07.04 Улаанбаатар хот/;<br>"Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн Монгол талын Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн анхдугаар хуралдаан боллоо /2023.01.05/;<br>"Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн дугуй ширээний уулзалтаар "Хамтран ажиллах" санамж бичиг байгууллаа /2023.09.11 БНХАУ-Эрээн хот/;<br>Дорноговь аймгийн Засаг даргатай "Хамтын ажиллагааны санамж бичиг" үзэглэлээ /2023.12.04 Дорноговь аймаг/;<br>Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран ажиллах "Санамж бичиг" байгууллаа /2023.12.12 Улаанбаатар хот/;<br>Сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зар, Төсөл хэрэгжүүлэх нэгжид ажилтан авах Нээлттэй сонгон шалгаруулалтын 5 удаагийн зар /2023.06.15-07.07-07.08-07.28-09.04/;<br>"Чөлөөт бүсэд мөрдөх журам"-ын төслийг хэлэлцлээ /2023.01.20/;<br>Чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн дэд станц бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэллээ /2023.03.20/; | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төрийн албан хаагчид тангараг өргөлөө /2023.04.14/; Хилийн боомтуудын ажиллах, амрах цагийн хуваарь, Сэрэмжлүүлгийн мэдээллийг давтагдсан тоогоор 50 гаруйг бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна. | | | |
| 1.2.3 | "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хийгдсэн холбоо сувагчлалын ашиглалт, үйл ажиллагааг зохион байгуулах; | Урсгал зардлаас | Холбогдох шийдвэр гаргуулсан байна. | "Замын-Үүд" чөлөөт бүсэд 63 км шилэн кабелийн сувагчлалын шугам хийгдсэн. | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах иргэн ААНБ-ууд болон хилийн мэргэжлийн байгууллагууд шилэн кабельд холбогдсон байна. | "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хийгдсэн авто зам, холбоо дохиоллын багц ажлын холбооны сувагчлалын ашиглалтын талаар "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн Дорноговь аймаг дахь салбарын зүгээс холбооны сувагчлалын гүйцэтгэл хангалтгүй тул өөрийн өмчлөлд авах боломжгүй талаар илэрхийлсэн. Шаардлагатай засвар үйлчилгээ хийгдсэн нөхцөлд өмчлөлд авахаар хэлэлцсэн. Хилийн 0108 дугаар анги, Замын-Үүд дахь гаалийн газартай хамтран чөлөөт бүсийн гүний гарцын шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай шилэн кабель татах ажлыг хийж, шилэн кабельд 2 төрийн байгууллагыг холбосон. | 75 | 70 | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах иргэн ААНБ-ууд болон хилийн мэргэжлийн байгууллагууд шилэн кабельд холбогдсон байна гэсэн зорилтот түвшиний хэдэн хувьд хүрсэн бэ? Хэдэн мэргэжлийн байгууллагаас хэдийг нь холбосон бэ? Тайлагнал хангалтгүй. |
| 1.2.4 | "Замын-Үүд" чөлөөт бүсийн 2-р ээлжийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын | Урсгал зардлаас | Шаардлагатай хөрөнгө оруулалтын судалгааг хийж, санал боловсруулсан байна. | 2013 онд хийгдсэн 2-р ээлжийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын зураг төсөв хийгдсэн. | "Замын-Үүд" чөлөөт бүсийн 2-р ээлжийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын | "Замын-Үүд" чөлөөт бүсийн 2-р ээлжийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын судалгааг хийсний үр дүнд нийт 182 тэрбум төгрөгийн хөрөнгө | 85 | 90 | "Замын-Үүд" чөлөөт бүсийн 2-р ээлжийн дэд бүтцийн бүтээн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын хөрөнгө оруулалтын судалгааг эхлүүлэх; | | | | ажлын хөрөнгө оруулалтын судалгааг хийж, эхлүүлсэн байна. | оруулалтын зардлыг тооцоолоод байна. Дээрх судалгааны үр дүнд үндэслэн "Замын-Үүд" чөлөөт бүсийн 2-р ээлжийн авто зам, хүнд даацын авто зам, гэрэлтүүлэг, холбооны байгууламж, салаа төмөр зам, дулаан хангамж, цахилгаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын ажлыг концессын зүйлийн жагсаалтад оруулахаар зардал, үр ашгийн тооцоог боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газарт 2023.01.25-нд хүргүүлэв. | | | байгуулалтын ажлын хөрөнгө оруулалтын судалгааг хийж, эхлүүлсэн үү ? |
| **1.3. Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх таатай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон хилийн дагуух эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах зорилтын хүрээнд:** | | | | | | | | | |
| • Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.19;<br>• Засгийн Газрын 2011 оны 187 дугаар тогтоол;<br>• Чөлөөт Бүсийн тухай хууль 7.1.7;<br>• Сангийн сайдын 2015 оны 196 тоот "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх" журам. | | | | | | | | • | • |
| 1.3.1 | Монгол, Хятадын "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс" байгуулах Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах | Урсгал зардлаас | Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтий | Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн Хамтарсан зохицуулах зөвлөл, хамтарсан гүйцэтгэх зөвлөл байгуулагдсан. | Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай" Монгол Улсын Засгийн газар, | Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүний хуралдааныг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр, 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр тус тус зохион байгуулсан. Уг хурлаас хоёр улсын хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн хуралдуулах шийдвэр гарч Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн анхдугаар хуралдааныг товлон хуралдуулах талаар Гадаад харилцааны яаманд 2023 оны | 90 | 90 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах; | | г хангасан байна. | | БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | 08 дугаар сарын 15-нд санал хүргүүлж, хятад талд дипломат шугамаар хүргүүлсэн.<br>2023 оны 4 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд Эрээн хотын чөлөөт бүсийн асуудал хариуцсан албаны төлөөлөлтэй уулзаж чөлөөт бүсийн төлөвлөлтийг уялдуулах, Эрээн хотын чөлөөт бүсийн бүтээн байгуулалттай газар дээр нь танилцах, хил холболтын цэг тохиролцох, хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн хурлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцсэн.<br>"Замын-Үүд", Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн улсын хил нэвтрэх цэг, байршил тогтоох асуудлаар ажлын хэсэг байгуулахад холбогдох албан хаагчдын нэрсийг хүргүүлэн Гадаад харилцааны яамтай хамтран ажиллаж байна.<br>Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг холбогдох байгууллагуудыг саналыг авч нэгтгэн Захирагчийн 2023 оны А/08 дугаар захирамжаар байгуулан, хурлыг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулав.<br>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо зохион байгуулагдсан Монгол-Хятадын дөрөв дэх | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удаагийн экспогийн үеэр зохион байгуулагдсан Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн дугуй ширээний уулзалтаар хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагаа бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх талаар санал солилцож цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хамтран ажиллах санамж бичгийг 2023.09.07-ны өдөр ӨМӨЗО-ны Эрээн хотын намын хорооны орлогч дарга, "Замын-Үүд" чөлөөт бүсийн захирагч нар үзэглэв.<br>Хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Монгол, Хятадын Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн анхдугаар хуралдааны бэлтгэл ажлыг ханган ажиллаж, хятадын талтай ажлын түвшний уулзалтыг 2023.12 дугаар сард багтаан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | | |
| 1.3.2 | Замын-Үүд Эрээний "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг уялдуулан боловсруулах , үе шаттай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Урсгал зардлаас | Хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг уялдуулах ажлыг зохион байгуулах. | Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай" хэлэлцээр, БНХАУ-ын Зөжяны их сургуулийн боловсруулсан Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төлөвлөлтийн төсөл хийгдсэн. | Замын-Үүд, Эрээний "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг уялдуулан боловсруулах , үе шаттай хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн байна. | Эдийн засаг, хөгжлийн яам, "Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны төлөөлөл БНХАУ-ын Эрээн хотын удирдлагатай "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн талаар 2023 он 04-р сарын 23, 24-ний өдрүүдэд уулзалт хийж цаашид хамтран хэрэгжүүлэх ажлын талаар ярилцаж нэгдсэн тохиролцоонд хүрсэн.<br>Хамтын ажиллагааны бүсийн Ерөнхий төлөвлөгөөг уялдуулан боловсруулах, хилийн цэс огтлон гарах цэгийг тогтоох, хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн | 90 | 90 | Арга хэмжээний хүрээнд тодорхой ажлууд хийгдсэн боловч гол үр дүн гараагүй байна. Хөгжлий ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаагүй, ажлын зураг |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хурлаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, бүсчлэл зэргийг хэлэлцүүлж, зохицуулах зөвлөлийн хурлаар батлуулахаар зөвшилцөв. Үүнд:<br>✓ Монгол, Хятадын Замын-Үүд-Эрээний Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, тээвэр логистик, үйлдвэрлэл гэсэн үндсэн дөрвөн чиглэлээр харилцан ашигтай тэнцвэртэй хөгжүүлэх;<br>✓ Монгол, Хятадын Замын-Үүд-Эрээний Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хооронд нь үндсэн болон ачаа тээвэр, аялал жуулчлал гэсэн гурван коридороор холбох;<br>✓ Хамтын ажиллагааны бүсийг хооронд нь хил дамнасан байгууламжаар холбох бөгөөд улсын хилийн шугамын явалтыг тодорхой байлгах зорилгоор улсын хилийг огтлон гарах цэгийн байршлыг Талуудын эрх бүхий байгууллага харилцан хэлэлцэн тохиролцож, газар дээр нь тогтоон протокол үйлдэж, дипломат шугамаар харилцан баталгаажуулах үүрэг | | | батлагдсан буюу тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх боловсруулалтын ажил хийгдсэн байна. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүхий ажлын хэсгийг байгуулж, БНХАУ-ын талд мэдэгдэх;<br>✓ "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс"-ийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн анхдугаар хуралдааныг товлон хуралдуулах саналыг БНХАУ-ын талд хүргүүлэх.<br>Мөн БНХАУ-ын талаас ирүүлсэн Зөжианы их сургуулийн боловсруулсан Эрээн хотын чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний саналыг Эдийн засаг, хөгжлийн яам болон 2023.07.04-нд зохион байгуулагдсан хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монгол талын бүрэлдэхүүнд танилцуулан "Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөг БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулахыг дэмжсэн. Энэхүү ажлын хүрээнд "Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг Захирагчийн ажлын албанаас боловсруулан Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд нараар 2023.12.15-нд батлуулав.<br>Зураг төсөл боловсруулахад шаардлагатай үнийн судалгааг Барилга, хот байгуулалтын | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | яамнаас 2023.09.20-ны 5/3405 дугаар албан тоотоор ирүүлж, санхүүжилтийг АХБ-ны "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-өөс 98.000 ам.долларыг төсөвлөн шийдвэрлүүлэхээр АХБ-тай тохиролцсон.<br>2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр ЭЗХЯ, БХБЯ, ГХЯ, ХХЕГ-тай хамтран Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах талаар санал солилцсон уулзалтыг зохион байгууллаа. | | | |
| 1.3.3 | Азийн хөгжлийн банкитай хамтран хэрэгжүүлж буй "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах төсөл"-ийг удирдлага зохион байгуулалтаар хангах; | Урсгал зардлаас | Төслийн хэрэгжилтийг 11 хувиар нэмэгдүүлсэн байна. | "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн хэрэгжилт 9 хувьтай хийгдсэн. | Төслийн хэрэгжилтийн явцтай уялдаж удирдлага зохион байгуулалтаар хангаг, хэрэгжилт 20 хувьд хүрсэн байна. | Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийг бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллаж байна.<br>**Тус төслийн /CS01/-багц ажлын хүрээнд:**<br>Барилга, дэд бүтцийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах багц ажлыг гүйцэтгэж буй "Сонголт дизайн" ХХК-иас ирүүлсэн Судалгааны тайлан, Явцын тайлан, Явцын тайлан 1-д тус тус санал, зөвлөмж өгч, баталгаажуулах ажлыг зохион байгуулж ажиллав.<br>Нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын явцадтулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулж ажлыг эрчимжүүлэх | 80 | 70 | Төслийн хэрэгжилтийн явцтай уялдаж удирдлага зохион байгуулалтаар хангаг, хэрэгжилт 20 хувьд хүрсэн байна зорилтын хүрээнд үр дүнгээ тайлагнах. Тайлагнал хангалтгүй. Нийт ажилаа дүгнэж үр дүнгээ тусган тодорхой |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зорилгоор 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Эдийн засаг, хөгжлийн яамнаас оролцогч талуудтай уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаас гарсан үүрэг даалгаврын дагуу төслийн ажилд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, нэгдсэн ойлголтод хүрэх зорилгоор оролцогч талуудтай уулзалт зохион байгуулж, гарсан шийдвэрийн дагуу ТХН-д ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл хүргүүлж ажиллав.<br>Төслийн хүрээнд хэрэгжиж буй дэд бүтэц, барилга байгууламжийн инженер геологийн тайлантай танилцаж, санал, зөвлөмж боловсруулан ажилласан.<br>CS01 багц ажлыг бүтээгдэхүүн тус бүрд авто замын, инженерийн шугам сүлжээний, гадна тохижилт ландшафт, хатуу хог хаягдал шилжүүлэх дахин боловсруулах төв, гүний гарцын барилга байгууламжийн зургийн даалгаврыг Барилга, хот байгуулалтын яамны холбогдох албан тушаалтнуудтай хамтран боловсруулан батлуулж, сум орон нутгийн байгууллагаас холбогдох техникийн нөхцөл гаруулан ажиллав.<br>Санхүүгийн гүйцэтгэл: 15%<br>Ажлын гүйцэтгэл: 36.7%<br>**CS-02 буюу "Тогтвортой менежмент үйл ажиллагааг дэмжих" багц ажлын хүрээнд:** | | | тайлагнах шаардлагатай. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төсөл хэрэгжүүлэх нэгжийн нийгмийн болон жендерийн хөгжлийн мэргэжилтэн С.Болорцэцэг 2022 оны жендерийн мониторингийн тайлан, байгаль орчны хамгааллын мэргэжилтэн Б.Цэрэндуламын байгаль орчны мониторингийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн С.Дэлгэрмөрөнгийн 2022 оны хяналт-шинжилгээний тайлантай танилцаж, зөвлөмж өгч ажиллаа.<br>CS-02 буюу "Чөлөөт бүсийн менежментийн зөвлөх компани" сонгон шалгаруулалтаар нэгдүгээрт эрэмбэлэгдсэн Жи Ди Пи Глобал девелопмент лимитэд (Англи), Максвелл Стамп лимитэд (Бангладеш) болон Боловсрол нийгмийн хөгжил төв ТББ (Монгол)-ын түншлэлтэй хэлэлцээ хийж, гэрээг баталгаажуулсан ба зөвлөх компанийн эхлэлийн тайлантай танилцаж, чөлөөт бүсэд өмнө хийгдэж байсан судалгааны материалуудыг хүргүүлэв.<br>2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банк, "Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын Алба, Төсөл хэрэгжүүлэгч нэгж, Максвэл Стамп, Монголын боловсрол, Нийгмийн Хөгжлийн төвийн хамтарсан "Жи Ди Пи Глобал хөгжил" консорциумын | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарааны уулзалтыг зохион байгуулан ажилласан.<br><br>Санхүүгийн гүйцэтгэл: 0%<br>Ажлын гүйцэтгэл: 3%<br>**/CS-03/ багц ажлын хүрээнд:**<br>Хилийн удирдлагын нэгдсэн систем /ХУН/ зөвлөх Жан-Баптист Муниер болон Б.Батпүрэвийн явцын тайлантай тухай бүр танилцан дүгнэлт, санал зөвлөмж хүргүүлсэн.<br>Олон улсын болон дотоодын зөвлөхүүдтэй хамтран Гаалийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харъяатын газар, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг оролцогч байгууллагуудтай уулзалт зохион байгуулав.<br>Зөвлөхүүдийн эцсийн тайлангийн эхний хувилбар болон сүүлийн хувилбар /ажлын даалгавар/-ыг хүлээн авч танилцаж, санал дүгнэлт бэлтгэн ажилласан.<br>“Замын-Үүд” чөлөөт бүсэд хөгжүүлэх шаардлагатай систем, түүний ажиллах цар хүрээ, хүчин чадал, техникийн шийдэл, санхүү төсөвтэй холбоотой ажилд хяналт хийх зорилгоор хөндлөнгийн зөвлөх авч ажиллуулан танилцуулга, дүгнэлт, зөвлөмж гаргуулсан.<br>2023 оны 10 дугаар сарын 03-ны Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эдийн засаг, хөгжлийн яам, “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба хамтран зөвлөхүүдтэй хурал зохион байгуулсан. | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хил хамгаалах ерөнхий газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1/2245 “Санал хүргүүлэх тухай”, Гаалийн ерөнхий газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2/4119 “Санал хүргүүлэх тухай” албан бичгүүдтэй танилцаж, саналыг нэгтгэн Гадаадын иргэн, харьяатын газар луу дахин санал авахаар хүргүүлж шийдвэрлэсэн.<br>“Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн Удирдах хорооны хуралдааныг 2023 оны 03 дугаар сарын 23, 04 дүгээр сарын 07, 07 дугаар сарын 07-ны өдөр тус тус зохион байгуулж, төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын тайланг хянах, хөлсөөр ажиллах гэрээний биелэлтийг дүгнэн санал дүгнэлт боловсруулж, төслийн Удирдах хорооны 2023.07.25-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>“Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн нэгжийн 5 ажилтан, 1 дотоодын зөвлөх сонгон шалгаруулах ажлыг Азийн хөгжлийн банкны журам, Төрийн болон орон нутгийн өмчөөр хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллалаа.<br>CS-02 багц чөлөөт бүсийн менежментийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт захиалагч | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын зүгээс өгөх саналыг боловсруулан тусгав.<br>Долоо хоног бүр Азийн хөгжлийн банк, Эдийн засаг, хөгжлийн яам, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн төлөөллүүдтэй уулзалт хийж төслийн ажлын явцын талаар хэлэлцэн санал солилцон цаашид авах арга хэмжээг тухай бүр төлөвлөн ажиллаж байна.<br>Санхүүгийн гүйцэтгэл: 80%<br>Ажлын гүйцэтгэл: 98% | | | |
| **1.4 Чөлөөт бүсийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, аялал жуулчлал, эко ногоон орчныг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах, гадаадын хөрөнгө оруулалтын гэрээ хэлцлийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд:** | | | | | | | | | |
| 1.4.1 | Гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах; | Урсгал зардлаас | Хамтран ажилласан байгууллагуудын тоо | Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсад суугаа элчин сайдын яамдууд болон олон улсын байгууллагууд. | Гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, хамтарсан байгууллагын тоо нэмэгдсэн байна. | Монгол Улсаас БНХАУ-ын Эрээн хотод суугаа консултай мэдээлэл солилцох уулзалтыг 2023.11.29-нд хийв.<br>Эдийн засаг, хөгжлийн сайдын БНСУ-д хийх айлчлалын хүрээнд "Замын-Үүд" чөлөөт бүсийн Хөрөнгө оруулалтын саналын танилцуулгыг бэлтгэж 2023.05.25-нд Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв.<br>Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газарт "Замын-Үүд" чөлөөт бүсийн мэдээллийг Хятад хэл дээр бэлтгэн хүргүүлэв.<br>Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд хөрөнгө | 80 | 90 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оруулалт татах чиглэлээр БНХАУ-ын Эрээн хотын Төрийн өмчит И-Шинь ХХК-тай 2023.05.20-нд уулзалт хийж, хамтран ажиллахаар тохиролцов.<br>Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хамтын ажиллагааны тухай "Санамж бичиг" байгуулан ажиллалаа.<br>Дорноговь аймгийн Засаг даргатай 2023.09.27-нд "Хамтын ажиллагааны санамж бичиг" үзэглэсэн.<br>Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яам;<br>Бүгд Найрамдах Турк улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яам;<br>Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яам;<br>Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам;<br>Бүгд Найрамдах Казахстан улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яам;<br>Бүгд Найрамдах Куба Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам;<br>Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам;<br>Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам;<br>Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам; | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам; Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдуудтай харилцаа холбоо тогтоож цаашид харилцаагаа өргөжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөж, албан и-мэйлээр холбоо тогтоосон. | | | |
| **2.1 Чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, газрын харилцааны үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;** | | | | | | | | | |
| 2.1.1 | "Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний дагуу чөлөөт бүсийн газрын харилцааны үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих; | Урсгал зардлаас | Холбогдох арга хэмжээг зохион байгуулах. | "Замын-Үүд" чөлөөт бүсэд бүртгэлтэй 81 аж ахуй нэгжид 113,93га газарт ашиглах эрхийн гэрчилгээ олгосон. | Газар олгох ажлыг зохион байгуулж, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдсэн байна. | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт газрын нэгдсэн мэдээллийн санд нэвтрэх эрх шинээр авахаар хүсэлт илгээж шинэ хэрэглэгчийн нэртэй болсноор иргэн, аж ахуй нэгжийг мэдээллийн санд бүртгэж цахимжуулах ажлыг эхлүүлж, дөрвөн аж ахуй нэгж байгууллагын байшинг кадастрын нэгдсэн системд бүртгэж баталгаажуулав. Үүнд:<br>-Эс Эп Ти чөлөөт бүс ХХК;<br>-Эм Энд Ти Эс хаус ХХК;<br>-Бүс ба зам санаачилга чөлөөт бүс ХХК;<br>-Эко эм жи чөлөөт бүс ХХК.<br>Үйл ажиллагаа явуулж буй хоёр аж ахуйн нэгж газраа барьцаалж зээл авсантай холбогдуулан хүсэлтийн дагуу зээлийн мэдээллийн санд бүртгэж баталгаажуулав.<br>Чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжийн хувийн хэргийн бүрдлийн хангаж ажиллав. | 90 | 90 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чөлөөт бүсэд барилгын бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлэхээр хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид холбогдох мэдээ мэдээллийг тухай бүр хүргэж, Дорноговь аймгийн газрын харилцаа, хот байгуулалтын газартай 2023 онд 2 аж аж ахуйн нэгжийн архитектур төлөвлөлтийн даалгавар, 3 аж ахуйн нэгжийн барилга байгууламжид улсын комисс ажиллуулж хамтран ажиллав. Барилгын ажлаа эхлүүлсэн 11 аж ахуй нэгжид "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Замын-Үүд дах салбартай хамтран цахилгааны техникийн нөхцөл олгов. | | | |
| **3.1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго** | | | | | | | | | |
| **3.1.1 "Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах" хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтын хүрээнд:** | | | | | | | | | |
| 3.1.1.1 | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгжүүдийн төлбөр, хураамжийг төсөвт төвлөрүүлэх, бүртгэх, бүртгэлээс хасах. | Урсгал зардлаас | Холбогдох арга хэмжээг зохион байгуулсан эсэх | Чөлөөт бүсийн бүртгэлийн гэрчилгээ олгогдсон 81 иргэн, аж ахуй нэгж байна. | Төсөл сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгжүүдийн төлбөр, хураамж холбогдох журмын дагуу төсөвт төвлөрсөн байна. Холбогдох хуулийн дагуу иргэн аж ахуй нэгжийг бүртгэх, | 2023 оны 12 дугаар сарын байдлаар "Замын-Үүд" чөлөөт бүсэд газар, эзэмшиж, ашиглаж буй нийт 81 аж ахуйн нэгжээс газрын төлбөр төлөх 35 аж ахуй нэгж байгууллагаас 28,7 сая төгрөгийг улсын төсөвт 100% төвлөрүүллээ. | 100 | 100 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүртгэлээс хасах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | | | | |
| 3.1.1.2 | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүдийн мэдээллийн цахим сан үүсгэх ажлыг зохион байгуулах; | Урсгал зардлаас | Цахим санд бүртгэсэн ААН-ийн тоо | Чөлөөт бүсийн бүртгэлийн гэрчилгээ олгогдсон 81 иргэн, аж ахуй нэгж байна. | Аж ахуй нэгжийн бүртгэл, мэдээллийн цахим сан бүрдсэн байна. | "Замын-Үүд" чөлөөт бүсэд газар ашиглаж буй 81 аж ахуйн нэгж, иргэний мэдээллийн санг дараах чиглэлээр шинэчлэв. Үүнд:<br>• Үйл ажиллагааны чиглэл<br>• Хөрөнгө оруулалтын мэдээлэл<br>• Хаяг байршил болон холбоо барих мэдээлэл<br>• Идэвхтэй-идэвхгүй үйл ажиллагаа явуулж байгаа эсэх<br>• Бүтээн байгуулалт хийсэн байдал<br>• Иргэний хөрөнгө оруулалтын мэдээлэл. | 90 | 90 | |
| **3.1.2."Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох" хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт** | | | | | | | | | |
| 3.1.2.1 | Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох; | Урсгал зардлаас | Олгосон тусгай зөвшөөрлийн тоо | Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 62 дугаар тушаалаар чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгож байна. | Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилт хангагдсан байна. | Зөвшөөрлийн тухай хууль болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан "И-Монгол Академи УТҮГ"-тай хамтран E-mongolia системд "Чөлөөт бүс-тусгай зөвшөөрөл" цахим цонх нээлгэн чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдаалах энгийн зөвшөөрлийг цахимаар захиалан авах боломж бүрдсэн. | 90 | 90 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Замын-Үүд" чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй 2 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлснийг хүлээн авч бүрдлийг ханган ажиллав. "Чөлөөт бүсэд мөрдөх нийтлэг журам", "Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам", "Чөлөөт бүсэд тамхи худалдах энгийн зөвшөөрөл олгох тухай журам"-ыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлагдах хүртэл хугацаанд чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл болон тамхи худалдах энгийн зөвшөөрлийг 2023 онд олгоогүй болно. /Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022.02.16-ны 01/77 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу олгоогүй/ | | | |
| **3.2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго** | | | | | | | | | |
| **3.2.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх зорилт** | | | | | | | | | |
| 3.2.1.1 | Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг ханган ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ; | Урсгал зардлаас | Холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх | Төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагаар хангагдсан байх. | Төрийн захиргааны удирдлагаар хангагдсан байна. Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлтэй | "Ажилтан албан хаагчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө", "Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө", "Ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө", "Дотоод хяналт | 98 | 90 | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамтран төрийн албаны сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулсан байна. | шалгалтыг зохион байгуулах төлөвлөгөө"-г боловсруулан 2023 оны 04 дүгээр сарын 03-ны А/14 тоот захирамжаар баталж, хэрэгжилтийг ханган, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллав.<br>2023 онд 10 албан хаагчийг ажилд томилж, 13 албан хаагчийг ажлаас чөлөөлсөн, 2 албан хаагчид жирэмсний болон амаржсаны амралт олгосон.<br>Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 4 албан хаагч, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 3 албан хаагчийг тус тус хамруулсан.<br>Байгууллагын дотоод сургалт, мэдээллийн цагийн хуваарийн дагуу хэлтсүүдийн мэдээллийн цаг, сургалтыг тухай бүр зохион байгуулан ажилласан.<br>БНХАУ-ын Бээжин хотод "Монгол Улсын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүтээн байгуулалт" сэдэвт мэргэшил дээшлүүлэх сургалтад 8 албан хаагчийн хамруулсан.<br>Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад холбогдох албан хаагчдыг тухай бүх хамруулсан. | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн "Өргөдөл, гомдлын тайлан ирүүлэх тухай" 03/492 тоот албан бичигтэй танилцаж, хариуг боловсруулан хүргүүлсэн.<br>Захирагчийн ажлын албанд 2023 оны байдлаар албан хаагчдаас ажлаас чөлөөлөгдөх тухай 3 өргөдөл, суралцах хугацаанд түр чөлөөлөгдөх тухай 2 өргөдөл, чөлөө хүсэх тухай 9 өргөдөл ирснийг бүртгэж, шийдвэрлэн ажиллав.<br>Захирагчийн ажлын албанаас 2023 онд:<br>– Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой захирамж 46;<br>– Байгууллагын боловсон хүчинтэй холбоотой захирамж 55;<br>– "Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба 2023 оны 01 сарын 01-ээс 12 сарын 10-ны байдлаар нийт 214ш албан тоотыг дээд газар, төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, иргэнд хүргүүлж, 193ш албан тоот ирсэн байна.<br>Архивын өрөөний баримт материалуудыг 1 давхраас 10 давхар луу нүүлгэн шилжүүлэв. Архивын ажилтан ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан 2023 оны 07 сарын 04-өөс 06, 10 дугаар сарын 03-наас 06-ны өдрүүдэд ажил хүлээлцэх ажлын хэсгийг байгуулан | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | архивын тооллогыг зохион байгуулсан. | | | |
| 3.2.1.2 | “Замын-Үүд” чөлөөт бүсийн ажилтан, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах зарим арга хэмжээг хэрэгжүүлэх; | Урсгал зардлаас | Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн эсэх | Нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. | Чөлөөт бүсийн ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгаа хангах талаар зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ажиллах нөхцөл сайжирч, ажлын үр дүн бүтээмж дээшилсэн байна. | Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, урамшуулах замаар цалин хөлсийг нэмэгдүүлэх, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тэтгэмж олгох, ажилтны нийгмийн баталгааг хангах ажлыг тухай бүр зохион байгуулж, 2023 онд улирлын ажлын гүйцэтгэлийн тайланг дүгнэх Үнэлгээний багийг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/15, 12 дугаар сарын 08-ны өдрийн А/46 тоот захирамжаар тус тус байгуулан хурлыг зохион байгуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн баталгаажуулав. 2023 оны жилийн эцсийн байдлаар улирлын ажлын үр дүнг харгалзан гүйцэтгэлийн үнэлгээгээр 18 албан хаагчийг 4 удаа цалингийн 50 хүртэл хувиар урамшуулалд хамруулсан. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 6 дугаар хавсралт, 2023 оны 241 дүгээр “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох | 95 | 90 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухай" тогтоолыг тус тус үндэслэн төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоож, ажлын гүйцэтгэл үр дүнг харгалзан 5 албан хаагчийн үндсэн цалин 40 хүртэл хувиар нэмэгдүүлсэн. Засгийн газрын 2022 оны 487, 488 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг батлагдсан төсөвт багтаан нэмэгдүүлэв. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газартай хамтран төрийн жинхэнэ албан хаагчийн тусгай шалгалт өгч тэнцсэн 5 албан хаагчийг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр төрийн албан хаагчийн тангараг өргүүлэв. | | | |
| **3.2.2. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх зорилтын хүрээнд:** | | | | | | | | | |
| 3.2.2.1 | Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих журмын дагуу хугацаанд нь гаргуулж, холбогдох тайлан мэдээг Авлигатай | Урсгал зардлаас | Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн эсэх | Авлигаас урьдчилан сэргийлэх 2022 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. | Албан хаагчдаар хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүрэн зөрчилгүй бөглүүлсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яам, Авлигатай тэмцэх газарт | Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих журмын дагуу хугацаанд нь гаргуулж, /19 албан хаагч ХАСХОМ мэдүүлсэн/ холбогдох тайлан, мэдээ, судалгааг гаргаж тухай бүр АТГ- хүргүүлсэн. АТГ-ын meduuleg.iaac.mn сайтад ажилд томилогдохоор нэр дэвшсэн иргэдийн мэдээллийг бүртгэн, хянан баталгаажуулсан. ХАСУМ-ыг тухай бүр мэдүүлэн хариу авч ажилласан. Ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх | 100 | 100 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцэх газарт хүргүүлнэ; | | | | холбогдох тайлан мэдээг тухай бүр хүргүүлсэн байна. Төлөвлөгөө биелсэн байна. | үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний дагуу ХАСХОМ бөглөхөд анхаарах асуудал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хууль эрх зүйн талаарх сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулан ажилласан.<br>Авлигатай тэмцэх газрын даргын 2023 оны А/31 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Маягт шинэчлэн батлах тухай" тушаалыг албан хаагчдад танилцуулан, цахим сүлжээнд байршуулан ажиллав. | | | |
| 3.2.2.2 | "Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах; | Урсгал зардлаас | Хяналт шалгалт зохион байгуулсан эсэх | Дотоод хяналтыг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. | Төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжсэн байна. | Захирагчийн 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/14 тоот захирамжаар Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах төлөвлөгөөг батлалж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үндэсний аудитын газраас 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 30-ны байдлаарх санхүүгийн тайлан, цалин хөлс, төсвийн гүйцэтгэлд төлөвлөгөөт аудит хийгдсэн. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн асуудлын бүртгэлээр төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 3 зөвлөмж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага ирсний хариу тайлбарыг Захирагчийн 2023 оны 11 сарын 21-ний өдрийн 01/217 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>Аудитаар илэрсэн зөрчил арилгах тухай АХГ-2023/343/НА-СТА-ТШЗ тоот | 100 | 90 | Дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулж батлуулсан Захирагчийн ажлын алба төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн эсэх. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан шаардлагын дагуу зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлэн ажиллалаа. | | | |
| **3.2.3.Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх зорилт** | | | | | | | | | |
| 3.2.3.1 | Чөлөөт бүсэд мөрдөгдөх нийтлэг журмын төслийг боловсруулан батлуулах; | Урсгал зардлаас | Нийтлэг журмын төсөл боловсруулсан эсэх | Чөлөөт бүсэд мөрдөгдөх нийтлэг журмын төслийг боловсруулан холбогдох албан тушаалтнууд, аж ахуй нэгжүүдтэй хэлэлцүүлэг зохион байгуулсан. | Чөлөөт бүсэд мөрдөгдөх нийтлэг журам, чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам, чөлөөт бүсэд тамхи худалдаалах энгийн зөвшөөрөл олгох журмууд батлагдаж эрх зүйн таатай орчин бүрдсэн байна. | "Зөвшөөрлийн тухай" хуулийн шинэчилсэн найруулга 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Чөлөөт бүсэд мөрдөх нийтлэг журам", "Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам", "Чөлөөт бүсэд тамхи худалдах, энгийн зөвшөөрөл олгох тухай журам"- ыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагууд, хөрөнгө оруулагч, иргэн, аж ахуй нэгжийн төлөөллүүдийг оролцуулан Эдийн засаг, хөгжлийн яамны хурлын танхимд хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулан журмын төслийн саналыг нэгтгэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яамны чөлөөт бүсийн хэлтэст 2023.01.25-нд хүргүүлэв. | 100 | 70 | Төслийг боловсруулж, батлуулахаар хүлээгдэж байгаа. Журам батлагдаагүй. |
| **3.3. "Чөлөөт бүсийн бүртгэл санхүү, төсвийн удирдлагыг хангах" зорилтыг хангахад чиглэсэн зорилт** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.1 | Санхүүгийн удирдлага, аж ахуйн үйлчилгээгээр хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ; | Урсгал зардлаас | Хугацаандаа тайлагнасан эсэх | Батлагдсан төсвийн санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр ашигтай зарцуулсан. | Төсвийн хөрөнгийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулагдсан байна. Ажлын албыг аж ахуйн үйлчилгээгээр бүрэн хангасан байна. | 2023 оны үндсэн үйл ажиллагааны зардалд 998,2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2023 оны 12 сарын 20-ны байдлаар нийт төсөв 654,6 төгрөгийн буюу 65,6 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Үүнээс:<br>- Цалин хөлс, нэмэгдэл урамшил 439,0 сая төгрөг буюу 65,6 хувь<br>- НДШ төлөх 56,5 сая төгрөг буюу 67,2%<br>- Байр ашиглалттай холбоотой зардал 57,7 сая төгрөг буюу 42,2%<br>- Хангамж, бараа материалын зардал 13,0 сая төгрөг буюу 90,4%<br>- Томилолт, зочны зардалд 10,0 сая төгрөг буюу 83,1%<br>- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 77,4 сая төгрөг буюу 99,1%<br>- Бараа үйлчилгээний бусад зардал 470 мянган төгрөг буюу 94 %-тай байна.<br>Үндсэн үйл ажиллагаатай холбоотой ажил үйлчилгээг төсвийн зарцуулах эрхийн хүрээнд гүйцэтгэгч байгууллагатай хийсэн гэрээ, нэхэмжлэх, падаан, акт, захирамж шийдвэрийг үндэслэн төлбөр тооцоог цаг хугацаанд нь тооцож, тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулан ажиллаж ирлээ.<br>"Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны | 100 | 100 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | www.zfz.gov.mn, "Шилэн данс", Сангийн яамны https://info.shilendans.gov.mn/ сайтад тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, цалингийн гүйлгээнээс бусад 5 сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээнүүдийг сар бүр мэдээлэх 48, хагас жилд 6, жил бүр 10, тухай бүр 96, нийт 160 мэдээг тус тус хуулийн хугацаанд нь тайлагнаж ил тодын хуулийг хэрэгжүүлэн ажилласан.<br>2023 онд төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлагын мэдээг баталгаажуулж, байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн харьцуулалт шалтгааны тайлбар болон таван сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээ, байгууллагын бүтэц орон тооны өөрчлөлт, 2023 оны төсвийн төлөвлөгөө, шилэн данс төрийн үйл ажиллагааны тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгох, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, өр авлага үүсгэхгүй байх, санхүүгийн сахилга батыг чангатгах, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэхэд анхааран, төсвийн тогтвортой, тасралтгүй байх зарчмыг ханган ажиллалаа.<br>Байгууллагын 1, 2 ,3-р улирлын санхүүгийн тайланг гарган, дүн | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллалаа. Засгийн газрын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн Э-тайлан цахим хуудсанд байршуулан Эдийн засаг, хөгжлийн яамаар баталгаажууллаа.<br>Батлагдсан төсвийн гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлтийн мэдээ, орлогын мэдээг сар бүрийн эцэст цаг хугацаанд нь ЭЗХЯамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлж, мэдээг баталгаажуулан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>2023 оны батлагдсан төсвөөр 41 ажилтан, албан хаагчдад цалин болон нэмэгдэл, урамшуулал, хоол унааны зардалд 671,9 сая төгрөгийг зарцуулах ёстойгоос тайлант хугацаанд давхардсан тоогоор 31 ажилтан, албан хаагчдад 289,1 сая төгрөгийн үндсэн цалин, 67,3 сая төгрөгийн нэмэгдэл цалин, 56,2 сая төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт, 28,1 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг цалингийн зардлаас тооцоолж олгон нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүр, хүн амын орлогын албан татварын тайланг улирал бүр гаргаж хуулийн хугацаанд нь https.//etax.mta.mn/, httpc.//ndaatgal.mn/ системд шивж оруулан баталгаажууллаа. | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Бичиг хэргийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш, шатах тослох материал, барилгын засварын материал, бусад хангамжийн бараа материалын нийт 20,648,220.00 төгрөгийн худалдан авалт хийж, 23,514,947.00 төгрөгийн зарцуулалтыг тухай бүр анхан шатны маягтаар ажилтан, албан хаагчдын албан хэрэгцээнд шаардах хуудсаар олгож ажилласан. Үүнд:<br>- Бичиг хэргийн материалын худалдан авалт 14 нэр төрлийн 303 ш, 2,458,320.00 төгрөг;<br>- Бичиг хэргийн материал зарцуулалт 41 нэрийн 1467 ш, 4,601,075.00 төгрөг;<br>- Сэлбэг хэрэгсэл, материалын худалдан авалт 14 нэр төрлийн 138 ш 10,226,000.00 төгрөг;<br>- Сэлбэг хэрэгсэл, материалын зарцуулалт 11 нэр төрлийн 131ш, 8,732,000.00 төгрөг;<br>- Түлш, шатах тослох материалын худалдан авалт 2 нэр төрлийн 1365,61 л, 5,790,800.00 төгрөг;<br>- Түлш, шатах тослох материалын зарцуулалт 2 нэр төрлийн 2194,90 л, 7,161,449.00 төгрөг;<br>- Барилгын засварын материалын зарцуулалт 4 нэр төрлийн 19 ш 90,750.00 төгрөг;<br>- Бусад хангамжийн материалын худалдан авалт | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 52 нэр төрлийн 711 ш 2,173,100.00 төгрөг;<br>- Бусад хангамжийн материалын зарцуулалт 67 нэр төрлийн 3055ш, 2,356,673.00 төгрөг. | | | |
| 3.3.2 | "Замын-Үүд" чөлөөт бүсийн төсвийн төсөөллийн төслийг боловсруулах; | Урсгал зардлаас | Хугацаандаа боловсруулсан эсэх | Батлагдсан төсвийн санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр ашигтай зарцуулсан. | Төсөв оновчтой үр ашигтай зарцуулагдахаар төлөвлөгдөх, төлөвлөсөн хэмжээнд хугацаандаа батлагдсан байна. | "Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны зохион байгуулалтын нэгжүүдээс 2024 төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд тусгах зардлын саналыг авч, нэгтгэн боловсруулж, 1,797,691.4 төгрөгийн төсвийн саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд 2023.04.05-ны өдрийн 01/108 дугаар албан бичгээр хүргүүлснээр УИХ-аас 2024 оны төсөв 1,503,030.400 төгрөгөөр батлагдлаа.<br>Эдийн засаг, хөгжлийн сайдаас ирүүлсэн төсвийн хуваарь хийх чиглэлийн дагуу 2024 оны төсвийн хуваарийг хийж Эдийн засаг, хөгжлийн яамны санхүүгийн хэлтэст хүргүүлэв. | 100 | 100 | |
| 3.3.3 | Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын ил тод байдлыг хангаж ажиллах; | Урсгал зардлаас | Ил тод байдлыг хангаж ажилласан эсэх | Албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалын судалгаа хийгдсэн. | Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаа тасралтгүй хэвийн үргэлжлэх нөхцөл хангагдсан байна. Хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, | 2023 оны бараа материалын тайланг анхан шатны бүртгэлийн маягтын дагуу сар бүрийн 05-ны дотор гаргаж, баталгаажуулан ажиллахдаа Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Улсын Секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт бусад холбогдох хууль эрх зүйн актуудыг дагаж мөрдсөн болно. | 100 | 100 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжирч тайлан мэдээ холбогдох газруудад хугацаандаа хүргэгдсэн байна. | Монгол улсын хууль тогтоомж, холбогдох төсөв санхүүгийн дүрэм журам, "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг мөрдөн байгууллагынхаа зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэн, ажилтан албан хаагчдын албан хэрэгцээнд шаардлагатай эд хөрөнгө бусад холбогдох материалыг тасралтгүй хангах, байгууллагын эд хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хариуцан ажилласан.<br>Сар бүрийн батлагдсан төсөвт багтаан хангамжийн материалын зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн холбогдох журмын дагуу худалдан авалт хийж, анхан шатны баримтын иж бүрдлийг ханган ажиллаж байна.<br>Үндсэн хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын өмч хөрөнгийн программд хөдлөл өөрчлөлтийг оруулах ажлыг хуулийн хугацаанд хийхээр төлөвлөсний дагуу Захирагчийн 2023 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн А/28, 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/45, 2023 оны 11 дүгээр 24-ний өдрийн А/45 дугаар захирамжаар байгуулагдсан “Эд хөрөнгийн тооллого явуулах үүрэг бүхий ажлын хэсэг” байгууллагын хагас жил, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийж, тооллогоор илэрсэн эд | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгийн тоо хэмжээ дутсан болон ашиглалттай холбоотой алдаа дутагдал гараагүй болно.<br>2023 оны 12 дугаар сарын байдлаар барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, программ хангамж дуусаагүй барилга, байгууламжийн нийт анхны өртгөөр 45,214,822,194.75 (Дөчин таван тэрбум хоёр зуун арван дөрвөн сая найман зуун хорин хоёр мянга нэг зуун ерэн дөрвөн төгрөг далан таван мөнгө) төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө байна. Үүнд:<br>- Барилга байгууламж: 5ш 805,576,622.20<br>- Авто тээврийн хэрэгсэл: 1ш 34,847,635.16<br>- Машин, тоног төхөөрөмж: 82 ш 138,089,589.00<br>- Тавилга, эд хогшил: 121ш 23,016,123.15<br>- Бусад үндсэн хөрөнгө: 7ш 31,655,582,315.24<br>- Программ хангамж: 2ш 1,705,000.00<br>- Биет бус хөрөнгө: 30305ш 1,804,306,857.00<br>- Дуусаагүй барилга, байгууламж:1ш 10,751,698,053.00<br>Хил хамгаалах ерөнхий газрын гүйцэтгэсэн "Замын-Үүд" чөлөөт бүсийн дохиолол, хамгаалалтын нэгдсэн системийн үндсэн хөрөнгийг Хил хамгаалах | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ерөнхий газарт балансаас балансt шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>Бараа материал 2023 оны 12 сарын 06-ны өдрийн байдлаар дараах үлдэгдэлтэй байна.<br>Үүнд:<br>- Бичиг хэргийн материал: 1,896,929.00<br>- Сэлбэг хэрэгсэл: 3,430,000.00<br>- Түлш, шатах тослох материал.<br>Мөн байгууллагын ажилтан, албан хаагчдын ашиглаж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг нэг бүрчлэн шинэчлэн бүртгэлжүүлж ажиллалаа.<br>Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 304 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хэлэлцэн, 20,070,974.55 (хорин сая далан мянга есөн зуун далан дөрвөн төгрөг тавин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг актлаж, устган санхүүгийн тайланд тусгаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тооллогын бүртгэлийн www.pcsp.gov.mn цахим системд мэдээллийг шинэчлэн оруулж тайлант хугацаанд илгээж эхний хагас жилийн байдлаар хөдөлгөөн орсон үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн биелэлтийг | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Захирагчийн 2023 оны 01/184 дугаар албан бичгээр хүргүүллээ.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу 2022 оны жилийн эцсийн байдлаарх анхны элэгдлээ нөхсөн үлдэгдэл өртөг 0.00 /тэг/ төгрөгийн хөрөнгө болох авто тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын жагсаалт гаргаж дахин үнэлгээ хийх бэлтгэл ажил ханган ажиллаж байна.<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны 463, 317 дугаар тогтоолоор, "Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд бүртгэлтэй "Тоёота Ланд круйзер-200" маркийн 09-85 УНҮ улсын дугаартай авто тээврийн хэрэгсэл, "Ниссан Максима" маркийн 07-69 УНҮ улсын дугаартай авто тээврийн хэрэгслийг Цагдаагийн ерөнхий газар, Орхон АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид тус тус балансаас балансад шилжүүлэх шийдвэр гарсны дагуу авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийг шилжүүлэх хүсэлтийг хүргүүлэн шийдвэрлүүлэв.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 сарын 03-ны өдрийн А-1/194 дугаар албан бичгээр | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илгээсэн "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 2.1.2, 2.1.3-т заасан ангиллын дагуу автомашины тоо төрлийг шинэчлэн тогтооход шаардагдах мэдээллийг тухайн албан бичгийн хавсралтад заасны дагуу байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй болон албан хэрэгцээнд нэн шаардлагатай байгаа авто тээврийн хэрэгслийн мэдээллийг боловсруулан Захирагчийн 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 01/88 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан. | | | |
| 3.3.4 | Авто зам, замын байгууламжийн арчлалт, үйлчилгээг сайжруулах; | Нэмэлт орлогоос | Холбогдох ажлын зохион байгуулсан эсэх | Чөлөөт бүсэд 13,5 км авто зам, байгууламж хийгдсэн. | Авто зам, замын байгууламжийн ашиглалтын түвшнийг сайжруулж, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцан хяналт тавьж ажилласан байна. | "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"- ийн хүрээнд хийгдсэн чөлөөт бүсийн 13,5 км авто зам, байгууламжийн арчлалт, үйлчилгээг сайжруулахаар Захирагчийн ажлыг албаны нэмэлт орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь 2023 онд авто машины төлбөр хураамж, нэмэлт орлого ороогүйн улмаас хийгдээгүй. | 0 | 0 | |
| 3.3.5 | Аудитын хяналт шалгалтад зохих журмын дагуу бэлтгэн, зөрчил | Урсгал зардлаас | Хуулийн хугацаанд шалгуулсан байх. | Санхүүгийн тайлан балансыг холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн. | Аудитын зөрчил дутагдалгүй ажилласан байх. | Үндэсний аудитын газар, Ай Жэй Эй Эйч-Аудит ХХК-тай гурвалсан гэрээ байгуулж холбогдох санхүүгийн материалыг хүргүүлэн аудит хийлгүүлж, "2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн | 100 | 100 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дутагдалгүй ажиллах; | | | | | тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна" дүгнэлтийг хүлээн авсан.<br>https://fas.audit.mn/ сайтад байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийн дагуу төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэн оруулж, Ай Жэй Эй Эйч-Аудит, Үндэсний Аудитын газрын хяналтын түвшнээр хянуулж баталгаажуулсан.<br>2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр хүргүүлж шилэн дансанд байршуулсан. | | | |

*Тайланг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД ............................ /Ч.ХҮРЭЛБААТАР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................